



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 8/13

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд бэлтгэвэл зохих өвс, тэжээл, хивэгний аюулгүй нөөцийн хэмжээ, шатах тослох материал болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй эрхлэгчид, худалдааны төвийн үйл ажиллагаанд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн удирдамжийн дагуу нэгдсэн арга хэмжээг 2023 оны 03 дугаар сарын 15-29-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Дээрх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, дүн мэдээллийг аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсэг (Ц.Ариунаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0186

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг дартын 2023 оны 03 дугаар
сарын 03-ны өдрийн 11 дүгээр
захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Ариунаа- аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний албаны дарга

Гишүүд:

Н.Дулам – (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

Д.Лхагважав- (аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Таримал ургамлын сорт, хорио цээрийн хяналтын улсын ахлах байцаагч)

Г.Балжиням- (аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах хяналтын улсын ахлах байцаагч, ахмад)

Э.Есөн-Эрдэнэ- (аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанарын хяналтын улсын байцаагч)

Г.Дэлгэрмаа- (аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Т.Эрдэнэбаяр- (аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ц.Эрдэнэжаргал- (Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Г.Амардэлгэр –(Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Өвөрхангай аймаг дахь улсын байцаагч)